



## **ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

### **1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3.10-т “Технологид суурилсан даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтын 44-т “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийг боловсруулахаар тус тус заасан бөгөөд хуулиар даатгалын төлөөлөгч, зуучлагчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хасах, даатгалын хохирол үнэлгээний эрх зүйн орчныг холбогдох хуультай уялдуулах, салбарын мэргэжлийн байгууллагын оролцоог хангах, даатгуулагч, даатгагчийн эрх ашгийг хамгаалах, тэнцвэржүүлэх хүрээнд мэргэжлийн оролцогчийн зарим үйл ажиллагааг хязгаарлах зэрэг зохицуулалтыг боловсронгуй болгохоор тусгасан.

### **2.Практик шаардлага**

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль нь 2004 онд батлагдсан бөгөөд уг хуулиар даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийг даатгалын мэргэжлийн оролцогчид хамааруулдаг. Гэтэл даатгалын мэргэжлийн оролцогч гэдэгт дээрх оролцогчдоос гадна даатгалын компани, даатгалын актуарч, аудитор зэрэг даатгалын салбарын оролцогчид бүгд хамаардаг. Энэ нь даатгуулагч иргэд, олон нийтэд буруу ойлголтыг бий болгож байна.

Даатгалын бүтээгдэхүүн, даатгалын зүйлээс хамааран даатгалын хохирлыг эмнэлгийн, гамшгийн, гал түймрийн, нисэх онгоцны, барилгын зэрэг нарийн мэдлэгтэй, мэргэшсэн этгээдүүд хохирлыг үнэлэх шаардлагатай байдаг боловч манай улсад ихэвчлэн автомашин, хөрөнгийн хохирлыг үнэлэх чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй даатгалын хохирол үнэлэгчид үйл ажиллагаа эрхэлж байна. Даатгалын хохирлын үнэлгээг хийж буй үнэлгээчид Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу Сангийн яамнаас хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулдаг хувь хүн байдаг бол Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийг компанид олгодог.

Олон улсад даатгалын хохирол үнэлэгч этгээд нь ихэвчлэн даатгалын компанийн ажилтан, хувь хүн эсхүл хөндлөнгийн даатгалын хохирол үнэлэгч гэсэн мэргэшсэн этгээд байж тухайн улсынхаа Даатгалын тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг.

Даатгалын бүтээгдэхүүнийг худалдан борлуулж, даатгуулагч иргэдтэй шууд харилцдаг даатгалын зуучлагч, төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэр дундаа даатгуулагчийн олгосон эрхийн хүрээнд түүний ашиг сонирхлын төлөө даатгалын гэрээний харилцаанд оролцож буй даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг боловсронгуй, мэргэшсэн түвшинд эрхлэх, энэхүү дундын зуучлагчдын зах зээлийг илүү ёс зүйтэй, ил тод, шударга өрсөлдөөнтэй зах зээл болгон хөгжүүлэх хүрээнд “Insurance intermediaries Act” буюу “Даатгалын зуучлалын хууль”-ийг олон улсад батлан мөрдүүлдэг. Энэ хүрээнд Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн нэрийг “Даатгалын зуучлалын тухай” хууль болгон өөрчилж, даатгалын хохирол үнэлэгчээр хувь хүн, хуулийн этгээд аль аль нь ажиллах боломжтой байх, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг олон улсын туршлагад нийцүүлэх хүрээнд Даатгалын тухай хуулиар зохицуулах нь зүйтэй байна.

Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийг одоогийн байдлаар 10 банк авч, даатгалын зуучлалын үйл ажиллагааг эрхэлж байна. Банк нь даатгалын компаниудтай байгуулсан гэрээний үндсэн дээр тэдгээрийн бүтээгдэхүүн үйлчилгээг өөрийн харилцагчдадаа түгээн борлуулж, борлуулалтын шимтгэлээс орлого олох, болзошгүй эрсдэлээс харилцагчид болон банканд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор даатгалын гэрээг зуучлан борлуулдаг этгээд бөгөөд олон улсад “банкашурэнс” гэж нэрлэн, нарийвчлан тусгайлан зохицуулсан байдаг. Энэ хүрээнд банкны даатгалын зуучлалын үйл ажиллагааг бусад мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанаас ялган тодорхойлж, олон улсын жишгийн дагуу эрхлэх үйл ажиллагаанд нь тавигдах шаардлагыг тодорхой болгосноор иргэд, аж ахуйн нэгж, даатгуулагчдад зөв зүйтэй ойлголтыг өгөх юм.

Даатгалын хураамжийн орлогын 20-40 хувийг даатгалын төлөөлөгч, зуучлагчийн шимтгэлийн зардал эзэлж байна. Гэтэл энэ хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа нь даатгалын компаниуд төлбөрийн чадвар, найдвартай байдал, туршлага, бүтээгдэхүүний хамгаалалт, онцлог шинж чанараар бус шимтгэлийн орлогын хэмжээгээр өрсөлдөх замаар бүтээгдэхүүнээ борлуулах сөрөг үр дагаврыг бий болгож байна. Үүнтэй холбоотойгоор шаардлагатай тохиолдолд зарим даатгалын хэлбэрийн хувьд даатгалын орлогын шимтгэлийн хувь хэмжээг хязгаарлах, даатгалын төлөөлөгч, зуучлагчийн бүртгэл, тайлагналыг боловсронгуй болгох, ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг зохицуулалтуудыг хуульд тусгаж, мэргэшсэн, шударга өрсөлдөөнт зах зээлийг бий болгох шаардлагатай байна. Мөн даатгуулагч, даатгагчийн эрх ашгийг хамгаалах, тэнцвэржүүлэх хүрээнд даатгалын зуучлагч, төлөөлөгчийн хариуцлагыг нэмэгдүүлэх, хуулийн нэр, томъёоны тодорхойлолтыг сайжруулж даатгалын зуучлагч, төлөөлөгчийн үйл ажиллагааны ялгаа, эрх, үүргийг хуулиар зохицуулах шаардлагатай байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос (цаашид “Зохицуулах хороо” гэх) тусгай зөвшөөрөлтэй 63 даатгалын зуучлагч компани байгаагаас 11 даатгалын зуучлагч нь давхар даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэхээр Зохицуулах хороонд бүртгүүлсэн байна. Давхар даатгалын зуучлалын үйл ажиллагаа нь ердийн даатгалын зуучлалын үйл ажиллагаанаас илүү мэргэшсэн байхыг шаарддаг боловч хуульд давхар даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбогдох эрх зүйн зохицуулалт тусгагдаагүй байгаа нь энэ төрлийн даатгалын зуучлалын үйл ажиллагаа хөгжих боломжийг хязгаарлахад нөлөөлж байна.

Хуулийн дагуу даатгалын төлөөлөгчийг даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн эрх олгосон этгээд гэж тодорхойлдог боловч даатгалын төлөөлөгч даатгагчийг төлөөлөхийн тулд Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авахаар заасан байдаг. Практикт даатгалын төлөөлөгчид тусгай зөвшөөрөл олгож байгаа нь даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө, ач холбогдол багатай байна.

Хуульд даатгалын төлөөлөгчийн эрх, үүргийг тодорхой болгох, мөн даатгагчийн нэрийн өмнөөс гэрээ байгуулдгийн хувьд даатгалын гэрээтэй холбогдон үүсэх хариуцлагыг даатгалын төлөөлөгч бус даатгагч хариуцах талаар тодорхой зохицуулалт шаардлагатай байна. Иймд нэг талаас даатгалын төлөөлөгчид олгож буй тусгай зөвшөөрлийн үр нөлөө, нөгөө талаас олон улсын туршлагыг харгалзан даатгалын төлөөлөгчийн зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг бууруулах замаар зөвшөөрлийн шат дамжлагыг багасгах боломжтой юм.

Даатгалын үнэлгээ ихтэй гэрээг зуучлахад нэг даатгагч дангаар даатгах боломжгүй нөхцөл байдал цөөнгүй үүсдэг бөгөөд энэ тохиолдолд даатгалын зуучлагч нь хамтын даатгалын үйл ажиллагаанд оролцох эрх зүйн орчныг бий болгож, гадаадын даатгагчид шууд зуучлахыг тодорхой хэмжээнд хязгаарлах замаар дотоодын даатгагчдыг дэмжиж, улмаар хамтын даатгалын үйлчилгээг өргөжүүлэх боломжтой байна.

Хуульд даатгалын зуучлагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, түүний өөрчлөлт, тэдгээрт тавих хяналттай холбоотой зохицуулалт тусгагдаагүйн улмаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, эцсийн өмчлөгчийг тогтооход хүндрэл үүсч, улмаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөмтгий байдал нэмэгдэх аюул их байдаг тул зохицуулагч байгууллагын хяналт тавих үйл ажиллагааны нэг хэсэг болох бүртгэл, зөвшөөрлийн үйл ажиллагааг хуульд тодорхой тусгах шаардлагатай байна.

Манай улсын даатгалын зах зээлд цахим буюу дэвшилтэд техник технологи, программ хангамж ашигласан бүтээгдэхүүн, үйлчилгээ хэдийнээ нэвтэрч эхлээд байгаа бөгөөд даатгалын зуучлалын үйл ажиллагаанд гар утасны программ хангамж, киоск (хиймэл оюун ухаант төхөөрөмж), цахим хуудас, цахим платформ ашиглан иргэд, даатгуулагчдад уламжлалт даатгалын үйлчилгээнээс илүү хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг зуучлан борлуулж байна. Гэвч хуульд орчин үеийн дэвшилтэд техник технологи ашиглан даатгалын гэрээ байгуулах, даатгалын бүтээгдэхүүнийг зуучлан борлуулахтай холбогдох зохицуулалт байхгүйн улмаас энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ даатгалын зах зээлд нэвтрэх, түүний хөгжлийг хязгаарлах, нөгөөтээгүүр уг бүтээгдэхүүн, үйлчилгээний улмаас иргэд, даатгуулагчид хохирох, энэ төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжгүй нөхцөл байдал бий болж байна. Хуульд цахим буюу дэвшилтэд техник технологи, программ хангамж ашиглан даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох зохицуулалтыг тусгаснаар даатгалын зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж, улмаар иргэдийн даатгалын тухай ойлголт, мэдлэгийн түвшин ахих чухал ач холбогдолтой юм.

## **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг Даатгалын зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга гэж өөрчилнө.

Даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын зуучлалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, даатгалын зуучлагч, төлөөлөгчийн үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлох, тэдгээрийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн төслийн боловсрууллаа. Даатгалын зуучлалын тухай хуулийг дараах агуулгаар өргөжүүлэн шинэчилнэ:

1.Хуулийн нэрийг “Даатгалын зуучлалын тухай хууль” гэж өөрчилж, даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

2.Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг сайжруулах;

3.Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтын асуудлыг холбогдох хуульд шилжүүлэх;

4.Даатгалын төлөөлөгчийн зөвшөөрлийн шаардлагыг бууруулах;

5.Даатгалын зуучлагч, төлөөлөгчийн үйл ажиллагааг төрөлжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн байдлыг нэмэгдүүлэх зохицуулалтуудыг нэмж тусгах;

6.Зохицуулагч байгууллагын эрх, үүрэг, бүртгэл, зөвшөөрлийн үйл ажиллагааны зохицуулалтуудыг боловсронгуй болгох;

7.Олон улсын жишгийн дагуу банкны даатгалын зуучлалын үйл ажиллагааны зохицуулалтыг бий болгох;

8.Даатгалын зуучлагч нь хамтын даатгалын үйл ажиллагаанд оролцох эрх зүйн орчныг бий болгож, гадаадын даатгагчид шууд зуучлахыг тодорхой хэмжээнд хязгаарлах замаар дотоодын даатгагчдыг дэмжих;

9.Давхар даатгалын зуучлалтай холбоотой зохицуулалтыг шинээр тусгах;

10.Даатгалын орлогын шимтгэлтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих зохицуулалтуудыг тусгах;

11.Даатгалын зуучлалын үйл ажиллагаанд цахим буюу дэвшилтэд техник, технологи, программ хангамж ашиглахтай холбоотой зохицуулалтуудыг тусгах зэрэг болно.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар**

Хуулийн төсөл батлагдсанаар даатгалын зуучлалын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт тодорхой болж, даатгалын зах зээл дэх мэргэжлийн оролцогчдын талаарх ойлголт, үүрэг хариуцлага нэмэгдэж, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой зохицуулалт илүү боловсронгуй болно. Мөн зөвшөөрлийн

шат дамжлага буурч, даатгалын зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж, иргэд, даатгуулагчдын даатгалын талаарх ойлголт нэмэгдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцүүлэн боловсруулна. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

---oOo---